

20~~24~~ он 05 сар 02 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсгийг удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТӨГТООХ нь:

1. “Таван Богд Холдингс” ХХК түүний охин компаниуд болон “ХААН” банк нарын хооронд 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан ЗЭНГ17/48 тоот Зээлийн эрх нээх гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
 - 1.1. Зээлийн эрхийн хэмжээг 8,000,000,000.0 /найман тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлэн нэмэлт эрхийн дунг 38,000,000,000.0 /гучин найман тэрбум/ төгрөг болгох, тус нэмэлт зээлийн эрхийн хүрээнд дараах нөхцөлийг мөрдөх, Үүнд:
 - 1.1.1. Төгрөгийн зээлийн шугамын хүү жилийн 15.6 /арван тав аравны зургаа/ хувь,
 - 1.1.2. Ам.долларын зээлийн шугамын хүү жилийн 7.5 /долоо аравны таван/ хувь,
 - 1.1.3. Ам.долларын зээлийн шугамыг зөвхөн Говь ХК ашиглах эрхтэй байх,
 - 1.2. Олон зориулалттай зээлийн эрхийн нөхцөлд “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл”-ийг дээд хэмжээ 10,000,000,000.0 /арван тэрбум/ төгрөг хүртэл, 12 сарын хугацаатай, төгрөгийн хүү жилийн 18.0 /арван найман/ хувь, хүүгийн хөнгөлөлт жилийн 13.0 /арван гурван/ хувь байх нөхцөлтэйгөөр нэмэх,
2. ЗЭНГ17/48 тоот “Зээлийн эрх нээх гэрээ”-ний хамтран зээлдэгчээс “Бета Карс” ХХК-ийг хасахыг зөвшөөрсүгэй.
3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
4. Зээлийн эрх нээх гэрээний нэмэлт гэрээ, барьцааны гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Дэд захирал /Э.Пүрэвлхам/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР

